

Байгууллагын 2013 оны эхний хагас жилийн зорилт, биелэлт, үр дүн

Тус газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Авлигын эсрэг хууль”-ийн Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, зорилтыг бодит ажил болгоход анхааран ажиллалаа.

Албан хэрэг хөтлөлт, иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Байгууллагад ирсэн албан бичиг, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг зохих журмын дагуу хүлээн авч, удирдлагад танилцуулан, холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч, шийдвэрлэлтэнд нь хяналт тавьж ажилласан.

Тайлант хугацаанд газрын даргын нийт 277 тушаал гарснаас хүний нөөцийн холбогдолтой 87, удирдлага зохион байгуулалттай холбоотой тушаал 190, Төсвийн ерөнхийлөн захирагч нартай хамтарсан тушаал одоогоор гараагүй байна.

Мөн харилцагч байгууллагуудаас нийт 1517 албан бичиг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба хариутай 137 албан бичигт тухай бүр зохих журмын дагуу хариу өгч, 85 албан бичгийг холбогдох байгууллагад уламжилж, 2760 албан бичиг төлөвлөн бусад байгууллагуудад хүргүүлсэн.

Иргэд, хуулийн этгээдийн санал гомдлыг авах зорилгоор санал хүсэлтийн хайрцгийг ажиллуулан, ирсэн 5 санал хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэн ажилласнаас гадна Шинэчлэлийн Засгийн газрын 11-11 төвд ирсэн тус байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 7 санал, 4 хүсэлт, 6 гомдлыг шуурхай шийдвэрлэж тухай бүр зохих хариуг хүргүүлэн ажилласан. Мөн тус байгууллагын эрхлэх асуудалд хамаарахгүй 9 санал, гомдол, хүсэлтийг холбогдох газруудад уламжилсан.

Тайлан мэдээ, биелэлтийн байдал

Тайлант хугацаанд Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 7 хоног тутмын шуурхай хуралдаанд худалдан авах ажиллагааны явц, төлөвлөгөөний биелэлтийн талаар 18 удаа танилцуулж, Засгийн газрын хуралдаанд 3 удаа худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл өгч гарсан шийдвэрийг захиалагч нарт хүргүүлэн ажилласан.

Худалдан авах ажиллагааны газрын тухайн сард хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 5 удаа гарган өгч, биелэлтийн мэдээг дараа сар бүрийн эхний 7 хоногт багтаан гаргаж Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэнээс гадна төсвийн ерөнхийлөн захирагч, Улсын их хурлын гишүүдэд Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын 2013 онд зохион байгуулах төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан, орон нутагт хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг 2013 оны 05 сарын 01-ний өдрийн байдлаар аймаг тус бүрээр нь гарган Шадар сайдын ажлын албаар уламжлуулан хүргүүлсэн. Мөн байгууллагын нэгдүгээр улиралын үйл ажиллагааны зорилт, биелэлт, үр дүнгийн талаарх тайланг Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн.

Монгол улсын 2013 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн дагуу Худалдан авах ажиллагааны газрын хөрөнгө оруулалтад тусгагдсан үйлчилгээний байрны их засвар, тавилга эд хогшил, тоног төхөөрмж, тээврийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, тайлан мэдээг тухай бүр Сангийн яам болон Шадар сайдын ажлын албанд, татвар, нийгмийн даатгал, үйл ажиллагааны хүрээнд гарсан төлбөр тооцоог батлагдсан төсвийн хуваарьт багтаан төлж, тайлан мэдээг сар, улирал бүр Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Сангийн яам, Шадар сайдын ажлын албанд гарган өгч ажилласан.

Орон нутгийн худалдан авах ажиллагааны 22 нэгжийн 2013 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, 1 дүгээр улиралын үйл ажиллагаа, худалдан авалтын тайланг нэгтгэсэн.

НЭГ. ДОТООД АЖЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Хүний нөөцийн чиглэлээр

Агентлагийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажлынбайрнышаардлагаднийцсэн мэдлэг чадвартай боловсон хүчнийг шилж, сонгон оновчтой байршуулахад байгууллагын хүний нөөцийн бодлогыг чиглүүлж, 2013 оны төсөв, орон тоонд багтаан 63 хүнийг ажилд авч мэргэжил, ур чадвар, ажлын туршлагыг нь харгалзан газрын нийт 8 хэлтэст байршуулан чиг үүргийг гүйцэтгүүлэн ажиллаж байна. Томилогдсон ажилтнуудыг боловсролоор нь авч үзвэл доктор 2, магистр 21 байгаагаас АНУ, Япон, БНСУ, Ирланд, БНХАУ зэрэг өндөр хөгжилтэй оронд суралцаж доктор, магистрын зэрэг хамгаалсан 9 ажилтан байна. Газрын удирдлага, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнүүдийн 75 хувь нь магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна. Мэргэжлээр нь авч үзвэл инженер 22, эдийн засагч 19, эрх зүйч 10, удирдахуйн ухааны менежер 12 ажилтан ажиллаж байна. Ажлын туршлагаар нь авч үзвэл Сангийн яам, Зам тээврийн яам, Барилга хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Эрчим хүчний яам, мөн бусад агентлагт худалдан авах ажиллагааны чиглэлээр ажилласан болон төрийн албаны ажлын туршлагатай 14 хүн ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчийн мэргэжлийн шалгалт өгсөн 8 албан хаагчийг томилох дүгнэлт ирсэний дараа Тангарагийг өргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Газрын даргын Б/41 тоот тушаалаар Цалин нэмэгдлийг шинэчлэн тогтоосон ба төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 21, зэрэг дэвийн нэмэгдлийг 9, докторын зэргийн нэмэгдлийг 2, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 3, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 1 ажилтанд тус тус олгож байна.

Худалдан авах ажиллагааны газрын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Шадар сайдаар батлуулан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд ханган ажиллаж байна. Мөн Төсвийн шууд захирагч менежерүүдтэй, менежерүүд төрийн албан хаагчидтай хуулийн хугацаанд үр дүнгийн гэрээ байгуулж хагас, бүтэн жилээр дүгнэж ажиллахаар төлөвлөсөн ба 2013 оны эхний хагас жилийн үр дүнгийн гэрээг дүгнэн үр дүнтэй ажилласан албан хаагчдыг шагнал урамшуулалд тодорхойлоод байна.

Дүрэм, журам, стандарт боловсруулах, хэрэгжүүлэх

Худалдан авах ажиллагааны газрын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Ёс зүйн хорооны журам”, “Архив албан хэрэг хөтлөлтийн журам”, “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах хөтөлбөр”, “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны газрын “Ёс зүйн хорооны журам”-ын хүрээнд Ёс зүйн хороо байгуулан ажиллаж байгаа бөгөөд нийт албан хаагчдын ажлын байр, албан тушаалын тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд ёс зүйн зөрчил дутагдалгүй ажиллах талаар тодорхой зүйл заалтын тусган ажиллаж байгаа бөгөөд эхний хагас жилийн байдлаар тус хороогоор ёс зүйн зөрчил дутагдал гаргасан аливаа асуудал шийдвэрлэгдээгүй. Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулах, албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж буй эсэхэд үйлчлүүлэгч иргэд хөндлөгийн хяналтыг бий болгох зорилгоор байгууллагын procurement.gov.mn вэб сайтад байршуулсан-оффис програмаар бүх албан хаагчдад танилцуулсан.

Худалдан авах ажиллагааны газрын “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах” хөтөлбөрийг боловсруулж Эх үрсийн баяраар албан хаагчдын 0-16 насны хүүхдэд мэндчилгээ дэвшүүлэх, бэлэг өгөх арга хэмжээг зохион байгуулснаас гадна, Спортын хамтлаг байгуулж, спортын 2 төрлөөр нийт албан хаагчдын дунд 1 удаа тэмцээн зохион байгуулж, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагчид спорт заланд долоо хоног бүр тоглож хэвшсэн. Мөн шинээр хүүхэд төрсөн 4 албан хаагчид тэтгэмж, 3-5 хоногийн цалинтай чөлөө, ар гэрт нь гачигдал тохиолдсон 1 албан хаагчид буцалтгүй тусламж, 7 хоногийн цалинтай чөлөө олгосон. ЗГ-ын “Хүндэт өргөмжлөл” шагналд 1, Хөдөлмөрийн хүндэт медаль, яамдын Хүндэт жуух, МЗХ-ны шагналуудад нийт 12 хүнийг шагнуулахаар ажил байдлын тодорхойлолтыг боловсруулж, анкет, материалыг бүрдүүлэн хүргүүлсэн.

Худалдан авах ажиллагааны газрын “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр” -ийн төслийг боловсруулж батлуулахаар ажиллаж байна. 2013 оны хагас жилийн байдлаар ЗҮХААХ-ийн дарга М. Угтахбаярыг Удирдлагын Академийн Төрийн удирдлагын гарагийн ангид, ЗУХ-ийн мэргэжилтэн Н.Энхбатыг ХБНГерман улсын Засгийн газрын тэтгэлэгт магистрийн сургалтанд хамруулаад байна.

Сангийн яамнаас боловсруулсан “Худалдан авах ажиллагааны хүний нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т тус газраас зохион байгуулах арга хэмжээний 3 зорилтыг тусгуулсан ба Засгийн газрын 2013 оны 89 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

- Цахим худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулж, худалдан авах ажиллагаанд оролцогч бүх талуудын 30-аас доошгүй хувийг сургалтанд хамруулсан байх зорилтын хүрээнд 810 хүнд сургалт зохион байгуулсан.
- Орон нутгийн Худалдан авах ажиллагааны нэгжүүдийн ажилтнуудыг худалдан авах ажиллагааны сургалтанд 100 хувь хамруулах ажлын хүрээнд 21 аймгийн 2500 гаруй хүнийг сургалтанд хамруулж чадавхижуулсан. Ингэснээр худалдан авах ажиллагааны нэгжийн бүх албан хаагчид АЗ гэрчилгээтэй болсон.
- Худалдан авах ажиллагааны газрын дэргэд “Сургалт, судалгааны төв” байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зардлыг 2014 оны улсын төсөвт суулгуулах саналаа Шадар сайдын ажлын албанд, “Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах зорилт, арга хэмжээг боловсруулах жишиг матриц”-д “Сургалт, судалгааны төв байгуулах” талаарх саналаа ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн.

Орон нутгийн нэгж байгуулах, чадавхижуулах чиглэлээр

Уг ажлын хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга болон тухайн орон нутгийн Худалдан авах ажиллагааны нэгжийн дарга нарт үлгэрчилсэн дүрэм, ажлын байрны тодорхойлолт, хууль, эрх зүйн гарын авлагыг тарааж, цаашид орон нутагтаа хэрхэн салбар нэгжээ байгуулах, худалдан авах ажиллагааг орон нутагт зохион байгуулахад анхаарах асуудлын талаар Монгол Улсын Шадар сайдаар үүрэг чиглэл өгүүлсэн.

2013 оны хагас жилийн байдлаар орон нутагт худалдан авах ажиллагааны 31 нэгж байгуулагдан, 146 албан хаагчтайгаар 2013 оны худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байгаа ба Орхон, Төв аймгийн Худалдан авах ажиллагааны албадуудад газар дээр нь очиж үйл ажиллагаатай нь танилцаж, 13 аймгийн нэгжийн албан хаагчдыг өөрийн байранд хүлээн авч зөвлөгөө, мэдээлэл өгч гарын авлага тараах материалаар хангасан.

Худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтыг 21 аймагт зохион байгуулж 2500 гаруй иргэнийг хамруулж, мэдлэг ур чадварыг нь дээшлүүлсэн. Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн газраас худалдан авах ажиллагааны хүрээнд явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг сурталчлах, нутгийн захиргааны байгууллага, Худалдан авах ажиллагааны орон нутгийн нэгж, аж ахуйн нэгж, иргэдэд хууль, эрх зүй, мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулж чадавхижуулах зорилгоор орон нутагт бүсчилсэн “АРД ТҮМЭН ТА - ХААН” форумыг 2013 оны 09 сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Байгууллагын 1 дүгээр давхарын дэвшилтэт технологи бүхий хүлээлгийн танхим, нэг цэгийн үйлчилгээний танхим, тендерийн нээлт, мэдээллийн танхим, үнэлгээний хорооны хурлын өрөөг ашиглалтанд оруулж иргэд, аж ахуйн нэгжүүдэд үйлчилж байна.

Нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлүүлж буй иргэд, аж ахуйн нэгжийн цаг хугацааг хөнгөвчлөх зориолгоор “Төрийн банк”-тай хамтран ажиллах гэрээг байгуулж Нэг цэгийн үйлчилгээнд байршуулан үйлчилж байна. Мөн байгууллагын 3 дугаар давхарын оффисын

ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл, зөрчлийг арилгах, худалдан авах ажиллагааны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг боловсронгуй болгох, захиалагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаарыг тогтоох, тайлагнах, хяналт тавих ажиллагааг оновчтой зохион байгуулах шаардлагыг харгалзан тус хуулийн 5 зүйлд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Сангийн яам, Хууль зүйн яам, Эдийн засгийн хөгжлийн яамдын төлөөлөлтэйгөөр Шадар сайдын 2013 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дугаар тушаалаар байгуулж Улсын их хурлын намрын чуулганаар эцэслэн хэлэлцүүлэхээр холбогдох газруудад хүргүүлсэн.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны алба байгуулах тухай Монгол улсын Засгийн газрын 144 дүгээр тогтоолыг батлуулсанаар нийслэл, 21 аймагт алба байгуулахтай холбогдуулан худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, зөвлөмж, үлгэрчилсэн дүрэм, ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг хүргүүлэн 2013 оны хагас жилийн байдлаар орон нутагт худалдан авах ажиллагааны 31 нэгж байгуулагдан, 146 албан хаагчтайгаар 2013 оны худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байгаа ба Орхон, Төв аймгийн Худалдан авах ажиллагааны албадуудад газар дээр нь очиж үйл ажиллагаатай нь танилцаж, 13 аймгийн нэгжийн албан хаагчдыг өөрийн байранд хүлээн авч зөвлөгөө, мэдээлэл өгч гарын авлага тараах материалаар хангасан.

Сангийн яамнаас зохион байгуулсан Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах сургалт, Мерси кор Олонулсынбайгууллага Авилгатай тэмцэх газартай хамтран “Монгол улсын бүх сумдын нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагуудад зориулсан сургалт”-д худалдан авах ажиллагааны нэгжийн албан хаагчдыг хамруулан, Худалдан авах ажиллагааны газраас орон нутгийн удирдлагуудыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх талаар мэдээлэл зөвлөгөө өгч хамтран ажилласан.

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Авлигын эсрэг хууль”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах эрх бүхий албан тушаалтныг томилж нийт ажилтнуудын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулж хуулийн хугацаанд Авилгатай тэмцэх газарт хүргүүлсэн. Мөн хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт гарсан албан хаагч болон 2013 онд нийтийн албан шинээр томилогдсон албан хаагчийн ХАСХОМ-ыг гаргуулан мэдээллийн сан бүрдүүлсэн. “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн дагуу үнэлгээний хорооны гишүүний ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх мэдэгдлийг тухай бүр гаруулан авч байна.

Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл олж авах эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилтийг ханган байгууллагын вэб хуудсыг боловсруулж ашилалтанд оруулсан ба Үндэсний дата төв, Датаком ХХК-иас www.procurement.gov.mn, www.e-tender.mn домэйн нэрүүд дээр байгууллагын вэб хуудсыг байршуулан ажиллуулж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааны явц, үр дүнгийн талаарх мэдээллийг цаг алдалгүй оруулж, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй шуурхай хүргэж байна. Мөн байгууллагын Twitter, Facebook хуудас зэрэг олон нийтийн сүлжээг ажиллуулж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч байгаагаас гадна “Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл олж авах эрхийн тухай хууль”-ийн дагуу байгууллагын үйл ажиллагааны тайлан, бүтэц бүрэлдэхүүн, гүйцэтгэх чиг үүрэг, санхүүгийн 2012 оны аудитийн дүгнэлт, зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хэрэгжилт зэрэг мэдээ, мэдээллийг оруулж ил тод байдлыг бүрэн ханган ажиллаж байна.

Худалдан авах ажиллагаанд оролцогч олон улсын байгууллага иргэдэд хүргэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын цахим хуудсыг англи хэл дээр болгох ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод, шударга байх зарчмын хэрэгжилтийг хангах талаар төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үүнд:


- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх, шударга өрсөлдөөнийг бий болгох, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж түүний хэрэгжилтийг хуулийн хүрээнд ханган ажиллаж байна.

- Авлигатай тэмцэх газартай Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх зорилгоор хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулж Авлигатай тэмцэх газар, Шадар сайдын хамтран ажиллах санамж бичгийг албажуулсан.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр Худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтанд батлагдсан 345 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны газраас 2013 онд 247 ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах төсөл, арга хэмжээг зохион байгуулахаас гэрээ байгуулсан 53, гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн 39, үнэлгээ хийгдэж буй 13, тендер зарласан 28, тендерийн баримт бичиг боловсруулж байгаа 15, нийт 148 арга хэмжээ буюу 60 хувийг зохион байгуулаад байна. Холбогдох яам, агентлагаас техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл ирүүлээгүй 59, нууцын зэрэглэлд хамаарах 9, 2013 оны төсвийн хуулиар батлагдсан төсвөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн 28, тендер зарлагдахгүй 3, нийт 99 төсөл арга хэмжээ буюу 40 хувийг хэрэгжүүлээгүй байна.

Худалдан авах ажиллагааны газраас
хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ /571 задаргаа/



Худалдан авах ажиллагааны газраас 2013 онд 185 бараа нийлүүлэгчийг сонгон шалгаруулах төсөл, арга хэмжээг зохион байгуулахаас гэрээ байгуулсан 48, гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн 25, үнэлгээ хийгдэж буй 7, тендер зарласан 51, тендерийн баримт бичиг боловсруулж байгаа 34, нийт 165 төсөл, арга хэмжээ буюу 89 хувийг зохион байгуулаад байна. Холбогдох яамдаас техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл ирүүлээгүй 19, нууцын зэрэглэлд хамаарах 1, нийт 20 төсөл арга хэмжээ буюу 11 хувийг хэрэгжүүлээгүй байна.

Худалдан авах ажиллагааны газраас 2013 онд 139 зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах төсөл, арга хэмжээг зохион байгуулахаас гэрээ байгуулсан 17, гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн 26, үнэлгээ хийгдэж буй 22, тендер зарласан 51, тендерийн баримт бичиг боловсруулж байгаа 1, нийт 117 төсөл, арга хэмжээ буюу 84 хувийг зохион байгуулаад байна. Холбогдох яамдаас техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл ирүүлээгүй 18, нууцын зэрэглэлд хамаарах 3, тендер зарлагдахгүй 1, нийт 22 төсөл арга хэмжээ буюу 16 хувийг хэрэгжүүлээгүй байна.

Үнэлгээний хороодын бүрэлдэхүүний 50 хувьд нь яам болон төрийн байгууллагууд, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл орсон. Мөн шаардлагатай гэж үзсэн зарим үнэлгээний хороодод Тагнуулын ерөнхий газрын төлөөллийг оруулан ажиллаж байна.

Захиалагч яам, агентлагуудад “Зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт ирүүлээгүй, ирүүлсэн боловч өөрчлөлт оруулах шаардлагатай төсөл арга хэмжээний дутуу ирүүлсэн материалыг ирүүлэх талаар холбогдох 13 яам, агентлагуудад 57 удаа албан бичгийг хүргүүлсэн.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 7 хоног тутмын шуурхай хуралдаанд худалдан авах ажиллагааны явц, төлөвлөгөөний биелэлтийн талаар 16 удаа

танилцуулж байгаа бөгөөд захиалагч нартай холбоотой мэдээ мэдээллийг цаг тухайд нь хүргүүлж ажиллаж байна. Мөн Засгийн газрын хуралдаанд 3 удаа худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл өгч гарсан шийдвэрийг захиалагч нарт хүргүүлсэн.

Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд

“Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-т тусгагдсан “Тендерийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 100 хувь онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулж, захиалагч нь шийдвэрлэдэг өнөөгийн тендерийн тогтолцоог өөрчилж гүйцэтгэгч нь шийдвэрлэдэг болгох” заалтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх гэрчилгээ олгох сургалтын хүрээнд цахим худалдан авах үйл ажиллагааг танилцуулах сургалтыг 2013 оны 02 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд Орхон аймагт, 2013 оны 03 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд Ховд аймагт зохион байгуулсан.

Цахим гарын үсэг РКІ олгох өдөрлөгийг 2013 оны 1 дүгээр сар 25-ны өдөр ШУТИС -ын хурлын зааланд зохион байгуулж 130 иргэнд сургалт хийж, 2013 оны 03 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Зам тээврийн яамнаас Буянт-Ухаа спорт цогцолборт зохион байгуулсан “Road expo-2013” Олон улсын үзэсгэлэнд оролцож 200 иргэнд, 2013 оны 05 дугаар сарын 17-21-ний хооронд Мишээл expo төвд Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас зохион байгуулсан ICT Expo-2013 өдөрлөг оролцож 450 иргэнд худалдан авах ажиллагаа болон цахим худалдан авалтын талаарх мэдээлэл хүргэсэн.

Цахим худалдан авалтын мэдээллийг иргэд олон нийтэд хүргэхээр Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн бэлтгэсэн “Тендерийн хөтөч I”, “Тендерийн хөтөч II”, Eagle Телевизийн “Зочны цаг” нэвтрүүлэгүүдээр орж, сонины ярилцлага 2 удаа өгч цахим худалдан авах ажиллагааны системийн талаар сурталчилсан. Мөн цахим худалдан авах ажиллагааны системийн талаар иргэд ойлгоход хялбар заавар, гарын авлагыг видео хэлбэрээр бэлтгэн /www.youtube.com/ вэб сайт дээр байршуулан 1300 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр ханган ажилласан.

Цахим худалдан авах ажиллагааны MEPS системд нийт 267 аж ахуйн нэгжүүдийг бүртгэн цахим системийн хувийн нууцлалын кодыг олгож, 49 төсөл, арга хэмжээ буюу нийт худалдан авах ажиллагааны 13.9 хувийг зохион байгуулсан ба иргэдийн худалдан авах ажиллагаанд гардаг цаасны болон бусад үргүй зардлыг дунджаар 92.57 хувь буюу 9,9 сая төгрөгөөр, тендерийн материал бэлтгэх цаг хугацааг 2 дахин хэмнэсэн.

Цахим худалдан авах ажиллагааны системийн мэдээлэл солилцоог сайжруулах ажлын хүрээнд Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк, Капитал банк, Төрийн банк, Голомт банк, Хас банк, Хаан банкуудтай цахим тендерийн баталгаа гаргах системийн холболтуудыг хийж гүйцэтгэсэн. Татварын ерөнхий газрын мэдээллийн системийн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхитай холбоотой мэдээллийг цахим хэлбэрээр авч байгаа боловч системтэй шууд холболт хийгдээгүй байна.

2013 оны хагас жилийн байдлаар цахим худалдан авах ажиллагааны MEPS системээр нийт 49 тендер цахим хэлбэрээр зарлагдсан байна.

БНСУ-ын КОЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн “Монгол улсад цахим худалдан авах ажиллагааны систем нэвтрүүлэх” төслийн гүйцэтгэгч Самсунг СДС компани төслийн багийг урьж 2013 оны 02 дугаар сарын 18 өдрөөс 2013 оны 03 дугаар сарын 15-ны хооронд ажиллуулсан ба ажиллах хугацаанд цахим тендер шалгаруулалтын систем, цахим каталог систем, цахим дэлгүүр системийн сургалтыг албан хаагчид зохион байгуулж бараа, бүтээгдэхүүнийг кодлох, энэхүү кодоор тендер зарлаж, өргөн хэрэглээний зарим барааг цахим дэлгүүрээр нийлүүлэх ажлыг цаашид судлан байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны мэдээллийн нэгдсэн санг үүсгэж 310 төсөл, арга хэмжээний үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд яам, агентлагуудын 189 төлөөлөл, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн 118 төлөөллийн, ажлын явц, үр дүн, бусад шаардлагатай мэдээ мэдээллийн сан бүрдүүлэн ашиглаж байна.

Тус газраас зарласан тендерүүдийн урилгыг яамдын болон тухайн салбарын төрийн бус байгууллагын цахим хуудсанд тухай бүр байрлуулж байна. Мөн Төсвийн ерөнхийлөн захирагч, Худалдан авах ажиллагааны газрын даргын хамтарсан тушаалаар Худалдан авах ажиллагааны газрын хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний биелэлтийн явцыг тухайн яамдын холбогдох ажилтнуудад цахим сүлжээгээр 7 хоног бүр хүргүүлж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өгсөн чиглэлийн дагуу “Эбльсофт” ХХК ablecloud e-оффисын программыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж тус газрын нийт албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт, ирсэн, явсан албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тухай бүр хяналт тавин ажиллаж байна.

ГУРАВ. СУРГАЛТ СУРТАЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд

Агентлагийн үйл ажиллагааг олон улсын стандартад ойртуулж ажиллах, худалдан авах ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэхэд байгууллагын гадаад харилцааны бодлого шууд чиглэгдэн ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны газар нь Дэлхийн банкны Монгол дахь салбартай “Худалдан авах ажиллагааны хууль эрх зүйн хүрээг боловсронгуй болгох”, “Худалдан авах ажиллагааны чадавхийг сайжруулах” төслийн хүрээнд, КОЙКА олон улсын байгууллагатай “Цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх” төслийн хүрээнд, МЕРСИ КОР олон улсын байгууллагатай “Засгийн газрын худалдан авах ажиллагааг ил тод, үр ашигтай болгох, худалдан авах ажиллагааны бодлого, түүний хэрэгжилтэнд иргэний

нийгэм олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, орон нутгийн салбар нэгжийн чадавхийг нэмэгдүүлэх” төслүүдийн хүрээнд хамтран ажиллаж Турк, Дани, Итали, Австри, Герман зэрэг улсуудад 14 албан хаагчийг сургалтанд хамруулж, нийслэл 21 аймгийн 2500 гаруй иргэнийг худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтанд хамруулсан. Мөн дээрх төслүүдийн хүрээнд худалдан авах ажиллагааны талаар цуврал хөдөлгөөнт зурмал, цуврал нэвтрүүлгийн эхний 2 ангийг бэлэн болгож иргэдэд хүргээд байна.

“Монгол улсад цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх төсөл”-ийн хүрээнд БНСУ-ын КОЙКА олон улсын байгууллагын 6 мэргэжилтэнг урьж, 2013 оны 2 дугаар сарын 18-аас 3 дугаар сарын 15-ны хооронд манай байгууллагад хүрэлцэн ирж Цахим худалдан авах ажиллагааны хэлтсийг өргөтгөх зорилгоор 3 серверийг байрлуулж, үйл ажиллагааг хэвийн явуулахад тодорхой зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласан.

Дэлхийн банкинд тавьсан саналын дагуу худалдан авах ажиллагааны олон улсын түвшинд хүргэх, стандартыг нутагшуулах зорилгоор тухайн байгууллагын Зөвлөх 2013 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн манай байгууллагад 3 сарын хугацаатай Худалдан авах ажиллагааны талаар олон улсад мөрдөгдөж буй 18 төрлийн стандартыг хөрвүүлэн Монгол улсад нутагшуулахаар ажиллаж “Барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааны ISO-10845 олон улсын стандарт”-ыг Стандарчлал хэмжил зүйн техникийн Үндэсний хороогоор батлуулсан. Ингэснээр Монгол улсын худалдан авах ажиллагааг анх удаа MNS-10845 олон улсын стандартын дагуу зохион байгуулах боломж бүрдсэн.

Монгол Туркын Засгийн газар хоорондын хамтарсан эдийн засаг, худалдааны 7 дугаар хуралдаанд оролцож Бүгд Найрамдах Турк Улсын Худалдан авах ажиллагааны газартай хамтран ажиллах талаар санал солилцож, хуралдааны тэмдэглэлд “Туркийн тал олон улсын хэмжээнд өөрийн хуримтлуулсан туршлагыг онцлон тэмдэглээд, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд Монголд зарлагдаж буй олон улсын тендрүүдэд оролцох хүсэлтэй байгаагаа тэмдэглэсэн”.

БНТУ-ын Ерөнхий сайд айлчлалын үеэр Засгийн газар хоорондын хэлэлцээрт худалдан авах ажиллагааны чиглэлээр харилцан туршлага судлах, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах асуудлыг тусгуулахаар төлөвлөн Гадаад харилцааны яаманд саналаа хүргүүлээд байна.

Албан хаагчдын мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд

“Худалдан авах ажиллагааны газар, Мерси Кор Монгол олон улсын байгууллага хоорондын хамтран ажиллах санамж бичиг”-ийг байгуулан “Засгийн газрын худалдан авах ажиллагааг ил тод, үр ашигтай болгох, худалдан авах ажиллагааны бодлого, түүний хэрэгжилтэнд иргэний нийгэм олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, орон нутгийн салбар нэгжийн чадавхийг нэмэгдүүлэх” төслийг хэрэгжүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтыг 15 удаа орон нутгийн ЗДТГ, ХААА-ны албан хаагчид, захиалагч байгууллага, Иргэдийн

төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, төрийн бус байгууллагын албан хаагчид, иргэдийн төлөөллийг хамруулан зохион байгуулсан.

Дэлхийн банкны Монгол дахь салбартай “Худалдан авах ажиллагааны хууль эрх зүйн хүрээг боловсронгуй болгох” хүрээнд хамтран ажиллаж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтыг ХААГ -ын мэдээллийн санд бүртгэгдсэн төрийн бус байгууллагуудын төлөөлөлд 2 удаа зохион байгуулсан. Мөн Тогтвортой амжиргаа 2 төслийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтыг 8 аймгийн төрийн бус байгууллага, иргэний төлөөлөл болох 1100 гаруй хүнийг хамруулан зохион байгуулсан.

2013 оны 01дүгээрсар 25-ны өдөр ШУТИС-ын хурлын зааланд “Цахим худалдан авалт” нээлттэй өдөрлөг зохион байгуулж 130 гаруй хүнд, Худалдан авах ажиллагааны газарт 20 хүний багтаамжтай цахим сургалтын өрөөг тохижуулж , цахим худалдан авах ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтыг иргэд, аж ахуйн нэгжүүдэд тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд нийт 100 гаруй иргэнийг хамруулсан.

Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах зорилгоор Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран 2013 оны 02-р сарын 05-ны өдөр “Хөрөнгө орлогын мэдүүлэг хэрхэн гаргах”, 05 сарын 02 –ны өдөр, “Авилгын эсрэг хууль тогтоомж, түүний хэрэгжилт”, 2013 оны 04-р сарын 03-ны өдөр “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” гэсэн сэдвүүдээр 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 170 гаруй албан хаагчийг хамруулсан. Мөн 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдөр “Эбльсофт” ХХК-ны ахлах мэргэжилтэн Делмандахаарablecloudе-оффисын програмыг хэрхэн ашиглах талаарх сургалтыг газрын нийт албан хаагчдад явуулж, тус програмыг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт, ирсэн, явсан албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тухай бүр хяналт тавин ажиллаж байна.

Сангийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 84 тоот тушаалаар Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журамд өөрчлөлт орж Худалдан авах ажиллагааны газар нь АЗ төрлийн сургалт зохион байгуулахаас гадна Төрийн бус байгууллагуудад зохион байгуулж байгаа сургалтуудаас шалгалт авч гэрчилгээ олгох эрхтэй болсон.

Зохион байгуулсан арга хэмжээ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Монгол улсын Шадар сайдын эрхлэх хүрээний агентлагуудын ээлжит хуралдааныг зохион байгууллаа. Уг хуралдаанд Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд болох Худалдан авах ажиллагааны газар, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Оюуны өмчийн газар, Стандарт хэмжил зүйн газар тус тус оролцож агентлагуудын

үйл ажиллагааны явц болон цаашид хийх үйл ажиллагааны чиглэлийн талаар санал солилцож, холбогдох мэдээ, мэдээллийг хүргэлээ. Хуралдааны үеэр Худалдан авах ажиллагааны газраас 2013 онд хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний нэг болох “Францын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн Монголын талын хөрөнгө /Орхон, Эрдэнэт/-өөр барих цэвэрлэх байгууламжийн ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт болсон.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын нээлтийн арга хэмжээг 2013 оны 05 сарын 09-ны өдөр зохион байгууллаа. Нээлтийн арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуяг, Шадар сайд Дэндэвийн Тэрбишдагва болон албаны бусад хүмүүс, Туркийн элчин сайдын яамны төлөөлөл, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, КОЙКА олон улсын байгууллага, МЕРСИ КОР олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөлүүд оролцсон. Нээлтийн үйл ажиллагааны үеэр Худалдан авах ажиллагааны газрын дарга Д. Энхжаргал газрын үйл ажиллагаа, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг хийсэн. Мөн нээлтийн арга хэмжээний үеэр Татварын Ерөнхий газар тендерт оролцогч аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн мэдээллийг ажлын 3 хоногт багтаан гарган өгч байхаар болсон нь онцлог явдал байсан.

2013 оны 1 дүгээр сар 25-ны өдөр Цахим гарын үсэг РКІ олгох өдөрлөгийг ШУТИС-ын Төв номын сангийн Е-Тестийн лабораторид зохион байгуулж, цахим гарын үсэг РКІ олгож, тус системийн талаар дэлгэрэнгүй танилцуулгыг 130 иргэнд хийсэн.

2013 оны 03 дугаар сар 06-07 өдрүүдэд Зам тээврийн яамнаас Буянт-Ухааспорт цогцолборт зохион байгуулсан “Road expo-2013” Олон улсын үзэсгэлэнд худалдан авах ажиллагааг сонирхсон аж ахуй нэгж, иргэдэд мэдээ мэдээлэл өгч, цахим худалдан авалтын талаар дэлгэрэнгүй танилцуулж, сурталчилгааны материал болох 100 CD, 100 гарын авлага, 700 брошурыг тараан 200 иргэнд, 2013 оны 05 дугаар сарын 17-21-ний хооронд Мишээл expo төвд Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас зохион байгуулсан ICT Expo-2013 өдөрлөг оролцож 500 CD, 500 гарын авлага, 1200 гаруй брошурыг тараан 450 иргэнд мэдээлэл хүргэсэн.

Албан хаагчдын чөлөөт цаг, амралтыг зөв, зохистой өнгөрүүлэх зорилгоор 2013 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр “Идэвхитэй хөдөлгөөн-Эрүүл амьдрал” сэдэвт цасны, баярын арга хэмжээг зохион байгуулсан. Биеийн тамир спортыг хөгжүүлэх, ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 9 хүний бүрэлдэхүүнтэй Спорт хамтлаг байгуулж, 2013 оны 06 дугаар сарын 08-ны өдөр спортын 2 төрлөөр нийт албан хаагчдын дунд тэмцээн зохион байгуулсан. Мөн дээрх зорилгоор албан хаагчид спорт заланд долоо хоног бүр тоглож хэвшсэн.

Эх үрсийн баяраар албан хаагчдын 0-16 насны хүүхдэд мэндчилгээ дэвшүүлэх, бэлэг өгөх арга хэмжээг зохион байгуулснаас гадна, байгууллага цэцэгжүүлэх 2 сарын аяныг зохион байгуулж, нийт хамт олныг хамруулснаар 100 гаруй цэцэг тарьж ургуулсан байгууллагаа цэцэгжүүлсэн.

Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагаатай танилцах чиглэлээр

Их хурлын Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, УИХ-ын гишүүн Б.Болор, Н. Батцэрэг, З. Баянсэлэнгэ, Зам тээврийн яам, Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга нар, Архангай, Хэнтий аймгийн Засаг дарга нар, захиалагч агентлагын дарга удирдлагууд Худалдан авах ажиллагаа газрын үйл ажиллагаа, тендер шалгаруулалтын ажлын явц болон хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар ирүүлэх талаар санал солилцсон.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитийн чиглэлээр

Худалдан авах ажиллагааны чанар хүртээмж, үйлчилгээний үр дүн, тайлан, мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлийг зохион байгуулан, байгууллагын санал хүсэлтийн хайрцагт ирсэн 5 саналыг шийдвэрлэн, Шинэчлэлийн Засгийн газрын 11-11 төвд ирсэн 26 саналыг шийдвэрлэн хариуг хүргүүлээд байна.

Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхий тухай хууль, бусад тогтоомж, заавар, журмын хэрэгжилтэд 9 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна.

Монгол улсын 2013 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн дагуу Худалдан авах ажиллагааны газрын хөрөнгө оруулалт, татвар, нийгмийн даатгал, үйл ажиллагааны хүрээнд гарсан төлбөр тооцоог батлагдсан төсвийн хуваарьт багтаан төлж, тайлан мэдээг сар, улирал бүр Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Сангийн яам, Шадар сайдын ажлын албанд тайлагнасан.

ДҮГНЭЛТ

Худалдан авах ажиллагааны газар байгуулагдаад удаагүй ч энэ хугацаанд “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны алба байгуулах тухай Засгийн газрын тогтоол, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр “Худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт” батлуулах зэрэг томоохон ажлуудыг богино хугацаанд хийж гүйцэтгэсэнээс гадна шинэ тутам байгууллагын чадавхийг бэхжүүлэх талаар гадаад, дотоодын олон байгууллагатай харилцаа, холбоо тогтоон тодорхой ахиц гаргасан байна.

Шинээр байгуулагдсан тус газар нь 2013 онд улсын төсвийн хөрөнгөөр зохион байгуулагдах нийт 345 ажлыг зохион байгуулах жагсаалтыг Монгол Улсын Засгийн газраар батлуулж, Төсвийн ерөнхийлөн захирагч бүртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хамтарсан төлөвлөгөөгөө баталсан нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг бүх шатанд хэрэгжиж буйг харуулж байна.

Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод, шударга байдлыг хангах талаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар, Авилгалтай тэмцэх газар болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байгаа нь хариуцлагаа ухамсарласан, цаашид гарах аливаа асуудлаас урьдчилан сэргийлэх чухал алхам болсон.

Худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор www.procurement.gov.mn, www.e-tender.mn вэб хуудсыг ажиллуулж төсөл арга хэмжээний урилга, явц, үр дүнгийн талаарх мэдээллийг цаг алдалгүй оруулж, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй шуурхай хүргэж ажилласнаар тендертэй холбоотой гомдол маргаан буурсан ба ТЭЗҮ, зураг төсөлтэй, батлагдсан төсөвт нь багтсан тендер зарлагдаж, шаардлага хангасан оролцогч хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарч байгаа нь тендерийн үнэлгээтэй холбоотой альваа гомдол, маргаан өмнөх жилүүдээс буурах нөхцөл болсон.

Татварын ерөнхий газраас тендерт оролцож буй аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхитай холбоотой мэдээллийг авч ажилласнаар аж ахуйн нэгж байгууллагууд татвараа хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнадаг болсон.

“Барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааны ISO-10845 олон улсын стандарт”-ыг Стандарчлал хэмжил зүйн техникийн Үндэсний хороогоор батлуулсан нь Монгол улсын худалдан авах ажиллагааг анх удаа MNS-10845 олон улсын стандартын дагуу зохион байгуулах боломж бүрдсэн.

“Худалдан авах ажиллагааны хүний нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Цахим худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтын хөтөлбөр” батлагдан сургалтууд зохион байгуулагдсан, орон нутгийн Худалдан авах ажиллагааны нэгжүүдийн ажилтнууд худалдан авах ажиллагааны сургалтанд 100 хувь хамрагдсан.

Худалдан авах ажиллагааны газар нь Дэлхийн банктай “Худалдан авах ажиллагааны хууль эрх зүйн хүрээг боловсронгуй болгох”, “Худалдан авах ажиллагааны чадавхийг сайжруулах” төсөл, КОЙКА олон улсын байгууллагатай “Цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх” төсөл, МЕРСИ КОР олон улсын байгууллагатай “Засгийн газрын худалдан авах ажиллагааг ил тод, үр ашигтай болгох, худалдан авах ажиллагааны бодлого, түүний хэрэгжилтэнд иргэний нийгэм олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, орон нутгийн салбар нэгжийн чадавхийг нэмэгдүүлэх” төслүүдийг хамтран хэрэгжүүлсэн.

Худалдан авах ажиллагааны талаар цуврал хөдөлгөөнт зурмал, цуврал нэвтрүүлгийн эхний 2 ангийг бэлэн болгож иргэдэд хүргэсэн.